



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/09

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн  
чиглэл батлах тухай


Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хулд, Луус сумдын нутагт орших Дэлийн жоншны уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртэлх 251 км ашигт малтмал тээвэрлэлтийн автозамын чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Майн Ланд майнинг" ХХК-ний гүйцэтгэх захирал (Д.Чойжамц) -д үүрэг болгосугай.

Гурав. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Бямбацогт), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

432016024

Аймгийн Засаг даргын 2020 оны  
01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/09 дугаар  
захирамжийн хавсралт

ХУЛД, ЛУУС СУМЫН НУТАГ ДАХЬ “ДЭЛ”-ИЙН ЖОНШНЫ УУРХАЙГААС  
ГОВЬ-СҮМБЭР АЙМГИЙН ЧОЙР ХҮРТЭЛХ 251 КМ АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН  
СОЛБИЛЦОЛ

Цэгийн дугаар	Байршил	Уртраг	Өргөрөг	Зай /км/
1.	Дэлийн уурхай	105° 30' 44.0”	45° 30' 38.35”	0
2.	Луус	105° 46' 42.29”	45° 31' 0.25”	22
3.	Сайнцагаан	105° 55' 31.4”	45° 40' 49.5”	72
4.	Говь-Угтаал	107° 55' 24.6”	45° 40' 49.4”	166
5.	Чойр	108° 21' 26.44”	45° 20' 54.28”	251